

**БАГААНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
ХИЙГДСЭН АЖЛЫН ХОЛБОГДОХ ФОТО ТАНИЛЦУУЛГА**

2020 оны 12 дугаар сарын 25

Багануур дүүрэг

БҮТП байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар байгууллагын дүрэмд заасан үндсэн чиг үүргүүд болон хөгжлийн 2017-2020 оны Стратеги төлөвлөгөө, жил бүрийн Үр дүнгийн гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг 100% ханган биелүүлснээр: газар байршил, ТЭЗҮ болон ХЕТ, дэд бүтцийн зураг төсөл, хууль эрх зүй болон хөгжлийн бодлогын баримт бичгүүд, мэдээлэл технологийн хүрээнд НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.4 дэх **“Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ.”** гэсэн заалт бүрэн амжилттай хэрэгжсэн.

**2016 онд:**

- Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/447 дугаар захирамжаар:
- хүнд үйлдвэрлэлийн бүс: 133.5 га,
- хөнгөн үйлдвэрлэлийн бүс: 100,0 га,
- хүнсний үйлдвэрлэлийн бүс: 51.2 га,
- ургамал nano биотехнологийн үйлдвэрлэлийн бүс: 118.6 га нийт 403,3 га газар эзэмших эрхийн гэрчилгээг авч, гэрээнүүдийг байгуулсан.






- Засгийн газрын 272 дугаар тогтоолоор Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүлээн авч, ЗГ-ын хуулиар Паркуудын асуудал эрхэлсэн УУХҮЯ-ны сайдтай тусгай зөвшөөрлийн хугацаагаар хамтран ажиллах гэрээ байгуулсан.



- Паркийн ТЭЗҮ-д суурилсан техник технологийн түвшний үнэлгээг боловсруулсан.
- НЗД-ын А/757 захирамжаар БҮТП ОНӨТҮГ-ын бүтэц орон тооны дээд хязгаарыг батлуулсан.

**2017 онд:**

- Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 789.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтаар Мон-энержи Консалт ХХК шалгарсан.
- БҮТП-ийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах дунд хугацааны Стратеги төлөвлөгөөг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр боловсруулан, мөрдөн ажиллаж эхэлсэн.
- БҮТП-ийн ТЭЗҮ-д суурилсан паркийн аж үйлдвэрүүдэд шаардлагатай хүний нөөцийн судалгаа, материал түүхий эдийн бүсчилсэн нөөцийн судалгаа, угтвар ажлын төлөвлөгөө, үйлдвэрийн хог хаягдлын менежментийн төсөл зэрэг шинжилгээ судалгааны ажлуудыг иж бүрэн гүйцэтгэж мэдээлэлийн санд бүрдүүлсэн.





- Багануур дүүргийн Засаг даргын А/226 тоот захирамжаар 10.7 га газрыг паркийн эзэмшилд авч, Монхимо ХХК-тай паркийн нэгжийн гэрээг байгуулан, дээрхи газрыг тус компанийн хэрэгжүүлэх “Адуу” брэндийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулах гэрээг байгуулав.



- НЗДТГ-ын ХШҮХ-ээс жил бүр зохион байгуулдаг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад, Улаанбаатар хотын захирагчийн харъяа газруудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үзлэг, НЗД-тай байгуулсан үр дүнгийн гэрээг “Бүрэн хангалттай” үнэлгээтэй биелүүлж, Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон Стратеги төлөвлөлтийг тайлант онд бүрэн хангаж ажиллав.

2018 онд:



• 2018.01.11-ний өдөр ХЕТ болон дэд бүтцийн зураг төслийн ерөнхий захиалагч БХБЯ нь гүйцэтгэгчээр шалгарсан “Мон-энержи Консалт” ХХК-тай №2018/10 тоот гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн.

- УУХҮЯ нь ЭХЯ-наас эрчим хүчний техникийн нөхцөл гаргуулж чадалгүй гүйцэтгэгчтэй 2018.09.27-нд дуусах гэрээгээ сунгаж ажилласан. Шалтгаан нь:
  - Эрчим хүчний сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгохыг 2018.09.25-наас эхлэн 2019.03.01 өдөр хүртэл түр зогсоох шийдвэр,
  - ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар БҮТП-ийн ТЭЗҮ-ийг хэлэлцүүлээгүй
- Паркийн удирдлага 2013 онд тухайн үеийн ҮХААЯ-ны захиалгаар хийгдсэн БҮТП-ийн ТЭЗҮ-ийг тус яам гүйцэтгэгчээс хүлээн авсан акт баримт материалыг ТЭЗҮ-ийн хамт ЭХЯ-нд хүргүүлэн ажилласан.
- Паркийн дэргэд “Эрдэм шинжилгээ, судалгааны инкубатор инноваци” төв /ЭШСИИТ/ байгуулах төслийг боловсруулсан.
- ЭШСИИТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд МУИС, ШУТИС, ХААИС, Шинэ”АУИС” болон УХЭШХ, Биологийн хүрээлэнгүүдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж эхэлсэн.



- ҮХГ-аас БНХАУ болон ОХУ-ын Буриад Ард улсад зохион байгуулсан “Монгол улсад хөрөнгө оруулалт” зөвлөгөөнд оролцож БҮТГП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд болон хэрэгжүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт татах танилцуулга хийж ажиллав.



- МҮХАУТ-ын гишүүнээр элсэж, Дотоодод зохион байгуулагдсан бүхий л хөрөнгө оруулалтын форумд оролцож, гадаад орнуудын ЭСЯ-дад танилцуулга материал хүргүүлэн ажиллав.















- НЗДТГ-ын ХШҮХ-ээс жил бүр зохион байгуулдаг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад, Улаанбаатар хотын захирагчийн харъяа газруудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үзлэг, НЗД-тай байгуулсан үр дүнгийн гэрээг “Бүрэн хангалттай” үнэлгээтэй биелүүлж, Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон Стратеги төлөвлөлтийг тайлант онд бүрэн хангаж ажиллав.

**2019 онд:**

- ХЕТ болон дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажилд паркийн инженер мэргэжилтнүүд нягт хамтран ажиллаж, ТЭЗҮ-д тусгагдсан асар өндөр зардал бүхий тооцоолол, схемийг Дүүргийн ерөнхий дэд бүтцэд тулгуурлах замаар шинэчлэн боловсруулан өртөг зардлыг бууруулж чадсан.



- Дэд бүтцэд шаардлагатай техникийн нөхцөлүүдийг Дүүргийн дэд бүтцийн байгууллагуудаас гаргуулах ажлуудыг амжилттайгаар богино хугацаанд зохион байгуулж ажиллав.





- ЭХЯ-наас техникийн нөхцөл гаргуулах ажил мухардалд орж, БХБЯ нь цахилгааны хэсгийг зураг төслөөс хасах санал ирүүлснийг Паркийн удирдлага эс зөвшөөрч, 2019.12.03-ны өдөр Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн дарга нартай биечлэн уулзаж, асуудлыг танилцуулснаар шийдвэрлүүлсэн.
- НИТХТ-ийн 130 дугаар тогтоолоор Паркийн Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөг /ХЕТ/ батлуулсан.



- ЭХЯ-наас техникийн нөхцөл олгохын тулд эрчим хүчний горимын ачааллын тооцоог /ГАТ/ Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/-өөр заавал гүйцэтгүүлэх шаардлага тавьж, Захиалагч болон Гүйцэтгэгч нарын дундын гэрээнд энэхүү ГАТ-ны зардал тусгагдаагүй тул гурвалсан зөвшилцөлөөр шийдвэрлэж ажлыг тасалдуулахгүй арга хэмжээг авч ажиллав.

- 2008 онд Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зориулалтаар тухайн үеийн ҮХЯ нь хувийн компаниас конторын барилгыг 1067 м.кв газрын хамт худалдан авсан байв. Уг барилгыг УИХ-ын 2018 оны 61 дүгээр тогтоолоор УУХҮЯ-наас нийслэлийн өмчид шилжүүлсэн бөгөөд 2019.12.13-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/1309 дугаар захирамжаар БҮТП-д хүлээлгэн өгч, Паркийн даргын 2019 оны 12 сарын 23-ны өдрийн А/38 дугаар тушаалаар 175.0 сая төгрөгийн хөрөнгийг өмчид бүртгэн хүлээж авсан. Энэхүү конторын барилга нь хүнсний үйлдвэрийн зориулалттай, олон жил ашиглалт хамгаалалтгүй байснаас их хэмжээний эвдрэл гэмтэлд өртсөн байна. Уг барилгад капитал зэрэглэлээр засварлаж, Эрдэм шинжилгээ, судалгааны инкубатор, инновацийн төв /ЭШСИИТ/-ийг ажиллуулахаар төлөвлөсөн.





Нийслэлийн Засаг даргын 2019 оны  
06 дугаар сарын 21-ний өдрийн  
А/619 дүгээр захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2019 ОНД  
САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСВИЙН АЖЛЫН  
ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	/сая төг/	
			2019 онд	санхүүжих
1	Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын зураг төсөв /НД/	2019		74.9
2	Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны 210.0 га нутаг дэвсгэрт Орон сууцны VII хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2019		358.0
3	Багануур үйлдвэрлэл технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээ	2019		30.0
4	Багануур үйлдвэрлэл технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл	2019		35.0
5	Яармаг, Шинэ яармаг, Буянт-Ухаа хороололд шинээр барих холбооны худаг сувагчлалын байгууламж, АТС суурилуулах ажлын зураг төсөл	2019		82.7
6	Улаанбаатар хотын музейн барилгыг түүхэн дурсгалт байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөх барилгын зураг төсөл	2019		76.4
	ДҮН			657.0

• Нийслэлийн Засаг даргын А/619 дүгээр захирамжаар парсад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэв.

• Засгийн газар болон БСШУСЯ-ны хүсэлтээр Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад ШУҮТП байгуулах судалгаа хийх ажлын хэсэг 2 улсын хэмжээнд 10 газар сонгож, сонголтонд багтсан БҮТП-д 6,9,10 дугаар саруудад ирж ажилласан. Судалгааны багийн нэгдсэн дүнгээр хамгийн боломжтой нь “БҮТП” гэж дүгнэгдсэн.



- Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэлийг бүрэн хангаж 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдөр НЗДТГ-ын ХШҮХ-ийн дарга Х.Гантулгаар ахлуулсан салбар комисст үндсэн 4 чиглэлээр байгууллагын үйл ажиллагааг шалгуулан 95,8% буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авч амжилттай дүгнэгдсэн. /Нийслэлийн өмчит төсөвт үйлдвэрийн газруудын хэмжээнд 2 дугаар байр/




- НЗДТГ-ын ХШҮХ-ээс жил бүр зохион байгуулдаг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад, Улаанбаатар хотын захирагчийн харъяа газруудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үзлэг, НЗД-тай байгуулсан үр дүнгийн гэрээг “Бүрэн хангалттай” үнэлгээтэй биелүүлж, Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон Стратеги төлөвлөлтийг тайлант онд бүрэн хангаж ажиллав.

**2020 онд:**

- Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах үндсэн үйл ажиллагааг эхлүүлэх хөгжлийн 2 дахь шатны 2021-2025 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан баталсан.
- Паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаанаас бусад хэсэг нь 07 дугаар сарын 07-ны өдрийн Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын 1193/2020 дугаартай нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан.




- 05 дугаар сарын 27-ны өдөр ЭХЯ-наас 02/695 дугаартай ДҮТ-өөс горим ачааллын тооцоог хүлээн авч БХБЯ болон Мон-энержи Консалт ХХК-д хүлээлгэн өгөв.
- Дээрхи техникийн нөхцөлд 220 кВ-ын дэд станц байгуулахаар тусгаж, нийт хэрэгцээний 63 МВт эрчим хүчийг 2024 оноос Багануур Повер ХХК-ийн Цахилгаан дулааны станцаас хангахаар төлөвлөсөн байв. 2024 он хүртэл паркийн бүтээн байгуулалтыг тасралтгүй хөгжүүлэх, зарим тэргүүлэх төслүүдийг эхлүүлэх шаардлагатай учраас ЭХЯ болон ЦДҮС ТӨХК-тай уулзалт зохион байгуулж, Багануур-220 дэд станцаас 110 кВ-ын шугамаар авч болох эрчим хүчний нөөц, боломжуудыг хайж хамтран ажилласны үр дүнд 8-14 МВт эрчим хүчийг эхний ээлжинд 110 кВ-ын шугамаар авах боломжыг бүрдүүлж ажиллав.





- 7,3 км урт 110 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугам /ЦДӨХАШ/-ыг дэд станцын хамт байгуулах 9,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийслэл болон улсын төсөвт тусгуулахаар хугацаанд нь холбогдох бүх шатны газруудад хүргүүлсэн.
- Мөн хувийн хэвшлийн байгууллагад танилцуулж ажилласнаар Багануурт төмрийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж буй "МЕСЕС" ХХК-тай хамтран ажиллах үр дүнд


хүрсэн. Тус компанийн үйлдвэр паркийн Хөнгөн болон хүнд үйлдвэрийн бүсийн дунд зэргэлдээ байршилтай учраас нэгдсэн цахилгаан хангамжийн 7,3 км шугамыг 2 хэлхээтэй 1 тулгууртай байгуулж, паркийн эзэмшилд шилжүүлэх, хөрөнгө оруулалтын 50%-ийг хариуцах, өөрийн эзэмшлийн талбайгаас паркийн 110/35/10-ын дэд станц барих газар эзэмшүүлэхээр шилжүүлэн өгөх зэрэг хоёр талдаа харилцан ашигтай санал ирүүлснийг 2 дугаар сард НЗД бгөөд УБ хотын захирагч С.Амарсайхан болон Багануур дүүргийн засаг дарга Ц.Сандаг очир нарт танилцуулан үүрэг чиглэл авч өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Үүнд:





1. Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгэгч “Мон-Энержи Консалт” ХХК нь ЭХЯ-наас 07 дугаар сарын 30-ны өдөр олгосон “БҮТГП болон Төмрийн үйлдвэрийн эрчим хүчний нэгдсэн ерөнхий цахилгаан хангамж”-ын 51/2020/87 тоот дугаартай Техникийн нөхцөл болон 09 дүгээр сарын 16-ны өдөр олгосон “Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгаврын” дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөн зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж байна.



2. Мөн гүйцэтгэгч байгууллага нь зургийн ажлын дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний Зүүн өмнөд бүсийн салбарын ТӨХК болон БҮТП-тай 2020 оны 10 дугаар 28-ны өдөр гурвалсан уулзалт хийж, 220/110/35 кВ-ын Багануур дэд станц дээр очиж шинээр холбогдох дэд станцын гаргалгаа болон удирдлага тоноглолыг байршуулах талаар зөвшилцөн хэмжилтийн ажлыг гүйцэтгэлээ.





3. 7,3 км шугамыг барих ажлыг “МЕСЕС” ХХК нь геологийн судалгааны ажлаас эхлүүлсэн байна.



**БҮТП-ийн цахилгаан хангамжийн 1 дүгээр ээлжийн хөрөнгө оруулалтын тооцоо**

Д/д	Төслийн нэр	Төслийн нийт хөрөнгө оруулалт /сая.төгрөг/	Талуудын хөрөнгө оруулалт	
			“БҮТП” ОНӨТҮГ	“МЕСЕС” ХХК
1	Цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 110 кВ-ын АС-240 утастай 7.3 км шугам	4348.092	2174.046	2174.046
Нийт			4348.092	

Д/д	Төслийн нэр	Төслийн нийт хөрөнгө оруулалт /сая.төгрөг/
1	Цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 110/35 кВ-ын 2*25000 мВа чадалтай дэд станц	5,310.2
Нийт		



- БҮТП-ийн ХЕТ батлагдсан тул түүнд суурилсан гадна болон дотоод инженерийн дэд бүтцийн зураг төсөл бүрэн дуусч, Барилгын хөгжлийн төвд магадлалаар хянагдахаар бэлтгэл ажил хангагдаад байна.
- БҮТП-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар гүйцэтгүүлэн 2020.02.03-ны өдөр хүлээн авав.

- БҮТП-ийн Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийг “Нутаг консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлж 2020.07.20-ны өдөр актаар хүлээн авав.

  
**“НУТАГ КОНСАЛТИНГ” ХХК**  
 ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛС**  
 БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
 БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ  
 Магадлалын нэгтгэсэн зураг  
 дугаар: **119/2020**  
**МАГАДЛАЛ ХИЙГДСЭН**  
 Магадлал хариуцаж  
 Хэлтсийн дарга: **М.Орвог**  
 2020.07.20-ны өдөр

Тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ17-425/18 ЕГ Шифр: НК-2020/01

Улаанбаатар хот, Багануур дүүргийн 3-р хороо,  
 “БАГАНУУР ҮЙЛДВЭР, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ

## “ҮЙЛДВЭРИЙН АЛБАН КОНТОР”

(ажлын зураг)

ЗӨВШӨӨРСӨН:		ХЯНАСАЛ		ХЯНАСАЛ	
Албан тушаал	Нэр	Гарин үзэг	Гүйцэтгэгч	Албан тушаал	Нэр
Нийслэлийн Онцгой Байдлын газрын дарга, Хурандаа	Х.Чулгар		М.Орвог	“Нутаг консалтинг” ХХК-ийн захирал	Н.Шинэболд
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга	Л.Эрдэнэчулуун		М.Орвог	Албан тушаал / үргэн	Нэр
				Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дарга	Б.Мөнхбат

Улаанбаатар хот  
2020 он

**МОНГОЛ УЛС**  
 БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
 БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ  
 Магадлалын нэгтгэсэн зураг  
 дугаар: **119/2020**  
**МАГАДЛАЛ ХИЙГДСЭН**  
 Магадлал хариуцаж  
 Хэлтсийн дарга: **М.Орвог**  
 2020.07.20-ны өдөр

Барилга хот байгуулалтын сайдын  
2018 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн  
43 дугаар тушаалын 1 дүгээр заварлалт

Төсвийн дугаар: № 08/2020

**УЛААНБААТАР ХОТ, БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРОО,  
 “БАГАНУУР ҮЙЛДВЭР, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-Н  
 “ҮЙЛДВЭРИЙН АЛБАН КОНТОР”-ИЙН БАРИЛГЫН  
 АЖЛЫН ТӨСӨВ**

Төсөвт өртгийн дүн: 2 454 235 530 /тоогоор/  
 (Хоёр тэр бум дөрвөн зуун тавин дөрвөн сая хоёр зуун гучин таван мянга таван зуун гучин төгрөг) /үсгээр/

Зураг төслийн “НУТАГ КОНСАЛТИНГ” ХХК-ийн  
 Захирал ..... /Н. Шинэболд/

Төсвийн тооцоо хийгч: **М.Орвог**  
 Мэргэшсэн: **С. Энхболд**  
 Хянасан: **Л. Пэлээсүрэн**  
 Таргуулах төсөвчин, эксперт: **Л. Пэлээсүрэн**

Төсөв тооцсон огноо: 2020 оны 5-р сарын 01-ны өдөр

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**  
**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**  
 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН  
**МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ**

2020 оны 7 дугаар сарын 20 өдөр Дугаар: **119/2020** Улаанбаатар-15171  
Утас: 323022, 328097  
Факс:

<b>Барилга байгууламжийн байршил, нэр:</b>	Улаанбаатар хот, Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах “Багануур үйлдвэр, технологийн парк” ОНӨААТҮГ-ын “Үйлдвэрийн конторын барилга”-ын ажлын зураг, төсөв
<b>Зориулалт:</b>	Үйлдвэрийн конторын барилга
<b>Хүчин чадал:</b>	Оффисийн барилга нь тэнхлэгээрээ 7,5 м х 29 м хэмжээтэй зорилын давхартай ±0.00 түвшнээс дээш 5 давхар барилга
<b>Зөвхөндөгч:</b>	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
<b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b>	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
<b>Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:</b>	“Нутаг консалтинг” ХХК
<b>Регистрийн дугаар:</b>	РД: 6153356
<b>Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:</b>	2023.01.25
<b>Ажилбарын төрөл:</b>	1.2.2, 1.2.4, 1.2.5, 1.2.6, 1.3.3, 1.3.4 заалтын дагуу
<b>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</b>	Багануур дүүргийн Засаг даргын А/158 дугаар захирамж Газар эзэмших эрхийн 000010646 дугаартай гэрчилгээ, Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн ГЕМ3Х2019/07-009 тоот архитектур төлөвлөлтийн даалгавар
<b>Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:</b>	“Нутаг консалтинг” ХХК-ийн захирал болон Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга нарын хооронд 2019 оны 11 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан НХААГ-19/155 тоот зураг төсөл боловсруулах гэрээ
<b>Техникийн нөхцөлүүд:</b>	Олгосон байгууллага
<b>Техникийн нөхцөлүүд</b>	Дугаар, огноо
<b>Дулаан хангамж:</b>	“Багануур дулааны Стандарт ТӨХК”
<b>Усан хангамж, ариутгах татуурга:</b>	“Багануур-Ус” ААТҮГ
<b>Цахилгаан хангамж:</b>	“БЭӨБЦТСүлжээ” ТӨХК-ийн Багануур салбар
<b>Холбоо дохиолол:</b>	“МХС” ХХК-ийн Багануур

- Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулах боломжтой Нүүрс хийжүүлэх технологийг суурин газарт нэвтрүүлэх төсөлтэй танилцаж дүгнэлт гаргасан. /Нүүрс хийжүүлэх технологийг нэвтрүүлснээр түлшийг хэмнээд зогсохгүй экологи байгаль орчны бохирдлоос үүдэн гарах хүн амын эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөлөл

багасч, сум суурин газрын айл өрх байнгын халаалтын горимд шилжиж, утаагүй эко технологи нутагших боломж бүрдэнэ./

- ШУТИС-тай хамтран “Кластер ба инновацийн тухай ойлголт, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт зөвлөгөөнийг 11 дүгээр сарын 06-ны өдөр Багануурт зохион байгуулахаар товлосон боловч цаг үеийн нөхцөл байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшилсон.
- МУИС-тай хамтран “Шар сүүг дахин боловсруулж шим тэжээлийн болон эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн гаргах” инновацийн үйлдвэрийн төслийн судалгааны ажлыг ЭШСИИТ-д эхлүүлсэн.

**“КЛАСТЕР БА ИННОВАЦИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, БАГАНУУРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ”**  
сэдэвт зөвлөгөөний хөтөлбөр

**Зорилго.** Багануур дүүргийн ААНБ-уудын удирдлагуудад кластерын тухай ойлголтыг өгөх, паркийн үйл ажиллагааг сурталчлан таниулах

13.30-14.00	<b>2020.11.06-ны өдөр МХС ТӨХХК-ийн хурлын танхимд зочдыг хүлээн авч бүртгэнэ.</b>
14.00-14.10	<b>Нээлт</b>
	Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга Ч.Элбэгсайхан
	Илтгэгчдийг танилцуулах. Хөтөлгөч, Үйлдвэрлэл, технологийн кластер инженер Э.Энхзаага
14.10-14.25	Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын тухай товч танилцуулга дарга Ч.Элбэгсайхан
14.25-14.55	<b>Илтгэл №1</b>
	Кластерын тухай ойлголт, хэрэгжүүлэх арга зам /ерөнхий ойлголт, гадаад орны туршлага, кластерын бүтэцэд хамаарах газрууд, ач холбогдол/ ШУТИС-ийн багш нэр
14.55-15.25	<b>Илтгэл №2</b>
	Инновацийн тухай ойлголт, хэрэгжүүлэх боломж /ерөнхий ойлголт, гадаад орны туршлага, ач холбогдол/ ШУТИС-ийн багш нэр
15.25-15.40	<b>Илтгэл №3</b>
	ШУТИС-ийн танилцуулга /судалгаанууд, лабораторийн тухай, захиралга хамтрах ажил/ Багш нэр
15.40-15.55	<b>Илтгэл №4</b>
	Паркийн кластерын зохион байгуулалт БУТП
15.55-16.10	<b>Илтгэл №5</b>
	Паркийн инновацийн хөгжил БУТП-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер Д.Алтангэрэл
16.10-16.50	Хэлэлцүүлэг: Асуулт, Хариулт, Санал, Зөвлөмж
16.50-17.00	Хэлэлцүүлгийн хаалт.

Хамтран зохион байгуулагч: Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ  
Шинжлэх ухаан технологийн их сургууль  
Нийслэлийн Шинжлэх ухаан үйлдвэрлэл инновацийн газар

БАТЛАВ: МУИС-ийн ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ Ч.ЛОДЖИРВАСЛ  
БАГАНУУР УЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН  
БАТЛАВ: ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН


2020 оны ... дүгээр сарын ...-ны өдөр  
2020 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

**ШАР СҮҮГ ДАХИН БОЛОВСРУУЛЖ ШИМ ТЭЖЭЭЛИЙН БОЛОН ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАХ ИННОВАЦИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

№	Ажилбар	Хугацаа	Гүйцэтгэгч	Тайлбар
1	4521 дугаар бүтэцтэйгээр "Шар сүүнээс" гаргах арга, явцыг, технологийг ажиглах арга болон газарзүйн харилцаа, технологийн судалгаа, үйлдвэрлэл, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	2020.10.21 — 2020.10.31	МУИС-ийн Технологийн лаборатори Д.Полжавсрын ЭЗБН-ийн лаборатори Б.Минжигуур БУТП-ийн Э.Энх Заага мэргэжилтэн Э.Энхзаага Инженер Д.Алтангэрэл Э.Энхзаага	
2	Төсөл хамтран боловсруулах баг төвлөрөл	2020.10.25 — 2020.10.31	МУИС-ийн Технологийн лаборатори БУТП-ийн Э.Энх Заага мэргэжилтэн Э.Энхзаага	
3	БУТП-д судалгаа төсөл зэрэгжүүлэх боломжийг судлах. Үндэс → Шинэ бүтээгдэхүүний төлөвлөгөө, зорилгогч ачаа зориулалт судалгаа → Тухайн ачаа нийлүүлэх боломжийг судлах	2020.11.01 — 2020.11.30	МУИС-ийн Технологийн лаборатори БУТП-ийн Э.Энх Заага мэргэжилтэн Э.Энхзаага	
		2020.11.01 — 2020.12.10	Б.Туяагэрэл, И.Савруул, М.Номингаргал	Үйлдвэрийн хөгжлөл шар сүүний нийлүүлэлт байгуулалт
	→ Бүтээгдэхүүний үнийн судалгаа үйл	2020.12.01 — 2020.12.25	Э.Энхзаага Б.Минжигуур Б.Минжигуур М.Номингаргал	
	→ Ачаа ачаанд элсвэрлэл бүтээгдэхүүний хэмжээг тогтоох	2020.12.25 — 2021.01.02	Б.Туяагэрэл Б.Минжигуур Д.Алтангэрэл	
4	Зорилгогч ачаа ачаанд хангах тухай зарны төсвийг	2021.01.02 — 2021.01.15	Б.Туяагэрэл И.Савруул Д.Алтангэрэл	
5	Үйлдвэр байгуулах боломжийг байрны судалгаа	2020.12.01 — 2020.12.25	Б.Туяагэрэл Б.Минжигуур Д.Алтангэрэл	
6	Төсвийн тоногч төлөвлөгөө, төсвийн мөнгөний төсвийг	2021.01.15 — 2021.01.31	Б.Минжигуур Б.Туяагэрэл	
7	Үйлдвэр байгуулах байрны хэмжээг тодорхойлох	2021.02.01 — 2021.02.10	Б.Туяагэрэл Д.Алтангэрэл	
8	Үйлдвэр байгуулах байр сонгох	2021.02.10 — 2021.02.20	Б.Туяагэрэл Б.Минжигуур Д.Алтангэрэл	Байрны сонголт байгуулалт

- 2021 онд эхлүүлэх Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд улсын төсөв, эдийн засаг маш хүнд байгаа энэ цаг үед Хүнд үйлдвэрлэлийн бүсэд 28,5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх үүднээс Багануур ХК-ийн одоогоор ашиглалтгүй байгаа (“Породная станция”) төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламж, дэд бүтцийг ашиглах боломж байгааг судлан саналаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулсан бөгөөд Багануур ХК-ийн удирдлагатай хамтран ажиллахаар санал солилцож, шаардлагатай техникийн өгөгдөл мэдээллүүдийг хүлээн авч, төсөл боловсруулахаар ажиллаж байна.





**Галуут дэд станц**  
Багануур ХК-ны ашиглалтын талбайд байрлах 110/35/6кВ-ийн хүчдэлтэй 2х6300кВА чадалтай трансформатартай дэд станц



**Дулааны шугам**  
Дулааны станцаас Багануурын уурхайн хөрсний алсын овоолго тээвэрлэлтийн станцын барилга байгууламж конторыг холбосон цэвэр, бохир, дулааны шугам /одоогоор ашиглалтгүй/







**Төмөр замын туннель**  
Багануурын нүүрсний уурхайлалтын хөрсний алсын овоолгын цахилгаан зүтгүүрт төмөр замын Багануур Багахангайн магистрал төмөр замын доогуурх гарц



**Барилга байгууламж**  
Багануурын уурхайн цахилгаан зүтгүүрт хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламжууд /одоогоор ашиглалтгүй/

**Жилийн эцсийн байдлаар**

- Багануур дүүрэгт ҮТП байгуулах бэлтгэл ажлыг хангах бусад үйл ажиллагааны хүрээнд:
- 2017 онд УУХҮЯ-ны дэргэд байгуулсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсэгт хамтран ажиллаж, ҮТП-ийн хөгжлийн эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын таатай тогтвортой байдлыг хангах саналуудыг тусгуулж, тус яамнаас УИХ-д өргөн барьсан бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар энэхүү хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж, УИХ-аар батлах нь хүлээгдэж байна.
- БҮТП-ийн үйл ажиллагааг Нийслэл болон ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны аж үйлдвэржилтийн бодлогын зорилго зорилтууд, Алсын хараа-2050, Монгол Улсыг 2030 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал, Засгийн газрын “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэгт нийцүүлэх, дээд шатны байгууллагуудтай нягт хамтран уялдаа холбоотой ажиллах нь чухал шаардлагатай учир салбарын яамдтай /ХХААХҮЯ, БОАЖЯ, БШУЯ/ уулзалт зөвлөгөөн зохион байгуулан санал солилцож тодорхой чиглэлийг аван ажиллаж байна.







- Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн бүтцийн үндсэн нэгж байгууллага ШУУ-ийн Монхимо ХХК нь 20 гаруй жилийн туршилт судалгааны ажлын үр дүнд бий болсон “Адуу” брэндийн шинжлэх ухааны бүтээлийг паркад инновацижуулж, цуврал бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаж эхэлсэн ба дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ тогтвортой боловч үйлдвэрлэлийн хүчин чадлаас хамаарч бага хэмжээтэй нийлүүлэн, БНСУ-д экспортолж байна. Мөн ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаатай 5 оронд экспортлох зөвшөөрөл, сертификатуудыг авсан. Шинэ төрлийн корона вирусын цар тахалтай холбоотойгоор бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг түр зогсоож дотооддоо нийлүүлэлт хийж байна. Мөн Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөрөнгө оруулагчдад тогтмол танилцуулдаг ба Ковид-19 цар тахалын үед бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс нэг удаагийн амны хаалт, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган ажиллаж байна.

**“АДУУ БРЭНД” БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮН**

**Экинол үеий тосон түрхлэг**

- Адууны чөлөөгөөс гаргаж авсан 100 хувь байдалын сарагтай эргэвч
- өвчин намдаах
- үеийг зөвлөн эдийг нохон төлжүүлэх
- үеийг уян байдлыг нэмэгдүүлэх
- зөвлөн эдийн бэрхшээлтэй эдгээрт түрвэсгэж үйлчилгээтэй.

Утас: 8871-0857  
www.adu-brand.mn

**Капсултай кальцийн бэлдмэл**

- Бүх насны ясны сойрогшилтой хүмүүс
- Хүүхэд өсөж насландай өсөлтийн дүтгэгшлэл
- Жирэмсэн болон ямарч эхнэрийн дутагдалас урьдчилан сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Мөн ясны гүрвэл, бодомчийг эдгээрт, бодомчийг сайжруулах хэрэглээр хэрэглэнэ.

Утас: 8871-0857  
www.adu-brand.mn

**Нунтаг кальцийн бэлдмэл**

- Бүх насны ясны сойрогшилтой хүмүүс
- Хүүхэд өсөж насландай өсөлтийн дүтгэгшлэл
- Жирэмсэн болон ямарч эхнэрийн дутагдалас урьдчилан сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Мөн ясны гүрвэл, бодомчийг эдгээрт, бодомчийг сайжруулах хэрэглээр хэрэглэнэ.

Утас: 8871-0857  
www.adu-brand.mn

**Экинокс зүрхний бэлдмэл**

- Зүрх судсаны үйл ажиллагааг дэмжих
- Хүснэ бэлтгэсэн эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Зүрхний шалдас өчүүрүүлэх урьдчилан сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ

Утас: 8871-0857  
www.adu-brand.mn

**Картинэ үеийн бэлдмэл**

- Тамхи үеийг налуу хэлээр нь байлгах
- Үеийг түрвэсэн бууруулах
- Үеийг өвдөлт намдаах
- Үеийг шалдас, зөвлөн эдийг төлжүүлэх
- Үеийг уян байдлыг дэмжих нөхцөлөөр хангах
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ
- Эхнэрийн дутагдалас сэргийлэх янзга хэрэглээр хэрэглэнэ

Утас: 8871-0857  
www.adu-brand.mn



БНСУ-ын зах зээлд зарагдаж буй бүтээгдэхүүн



ХЯНАСАН:  
 БАГАНУУР ҮЙЛДВӨРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *[Signature]* Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАЙЛАН ГАРГАСАН:  
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Э.ЭНХЗАЯА